

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2016-11-28

Хууль, Улсын их хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль болон Монгол Улсын хууль тогтоомжийг 2016-2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд заасны дагуу Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж байна.

1995 онд батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, Байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, түгээх, боловсруулах, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалтыг Засгийн газар батлахаар хуульчилсан бөгөөд Байгаль орчны мэдээллийн сангийн тогтолцоо, мэдээллийн сангийн бүрдэл, байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээллийн сан, мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллага, хэрэгжүүлэх хугацаа, мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах байгууллага, мэдээллийн сан хэрэглэгчийн бүрэн эрх, үүрэг, мэдээллийн сан бүрдүүлэх ерөнхий шаардлага, сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл, санхүүжилт, төлбөрийн нөхцөл зэрэг байгаль орчны мэдээллийн санг бий болгож өгсөн.

Гэвч 2008 оны дээрх нэмэлт, өөрчлөлтөөр “Засгийн газар байгаль орчны төлөв байдлын талаархи тайланг хоёр жилд тутам 1 удаа Улсын Их Хурлын хаврын чуулганд өргөн мэдүүлэх бөгөөд түүнд дараахь асуудлыг тусгана:

1/байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээхэд зориулсан улсын төсвийн ба төсвийн бус хөрөнгийн зарцуулалт;

2/байгаль орчны төлөв байдлын болон байгалийн баялгийн нөөцийн хувьсал өөрчлөлт;

3/байгалийн баялгийн нөөцийн ашиглалт, нөхөн сэргээлт;

4/орчны бохирдлын эх үүсвэр, түвшин, түүнийг бууруулах талаар авсан арга хэмжээ, үр дүн.” гэсэн агуулга бүхий зохицуулалт хуулиас хасагдсан байна.

Харин Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлд “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тайланг хэлэлцэх”, 47 дугаар зүйлийн 47.2-т “Байнгын хороод тайланг дор дурдсан харьяаллаар хэлэлцэнэ”, 47.2.7-д “Байгаль орчны төлөв байдлын тайланг Байгаль орчин, хүнс, хөдөө, аж ахуйн байнгын хороо” тайланг хэлэлцэхээр тусгасан байна

Иймд дээрх хуулийн хийдлийг арилгах, хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн бодлоготой уялдуулан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Мөн 2012 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж “Байгалийн нөөцийн хамтын менежмент” гэсэн шинэ бүлэг (хуулийн Наймдугаар бүлэг, 45, 46, 47, 48, 50, 51, 52-р зүйл) нэмсэн бөгөөд энэ нь байгаль хамгаалах уламжлалт арга хэлбэрийг олон улсад түгээмэл хэрэглэгддэг шинэ үзэл санаатай хослуулж, “байгаль хамгааллын шинэ тогтолцоо”-г бүрдүүлэхэд чухал түлхэц болсон юм.

Байгалийн тодорхой баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн баримтлах журмыг байгаль орчны асудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах, нутгийн өөрөө удирдах болон засаг захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хариуцан хамгаалж буй нутаг дэвсгэрийнхээ байгалийн нөөцийг давуу эрхтэйгээр ашиглах, нутаг дэвсгэртээ нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс тухайн орон нутгийн төсөвт тусгаж, баталж, зарцуулалтад хяналт тавих зэрэг асуудлаар Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хавсаргав.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам